

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 4 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2018.04.23

Сумдын газрын даамлуудын сургалтыг 2018 оны 04 дүгээрсарын 09-10-ны хооронд аймгийн ГХБХБГ-т зохион байгууллаа.

Сургалтаар байгууллагын мэргэжилтнүүд хоорондоо холбогдох мэдээ, мэдээлэл, зөвлөмж чиглэлийг харилцан солилцож, мэдлэг туршлагаа нэмэгдүүлэн ажиллахаас гадна Авлигаас урьдчилан сэргийлэх олон нийтийн дэд зөвлөлийн дарга Д.Зандаръяа “Төрийн албан хаагчийн ёс зүй, авлигаас урьдчилан сэргийлэх” талаар сургалт зохион байгууллаа.



Газрын төлбөрийн орлого төвлөрүүлэлт:

Аймгийн ИТХ-ын 2017 оны 08 дугаар тогтоолоор 2018 онд газрын төлбөрийн орлого 132 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөгөө батлагдсан бөгөөд 2018 оны 4 дүгээр сарын байдлаар 61 сая төгрөг төвлөрүүлээд байгаа нь төлөвлөгөөтэй харьцуулахад 46,2%-ийн биелэлттэй байна.


Газрын кадастрын ажлын чиглэлээр:

2016-2017 онд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчилж авсан нийт 230 иргэдэд 690 ширхэг нууцлал бүхий үнэт цаасаар үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнээс: 2018 оны 04 сарын 24-ны өдөр Сүмбэр сумын иргэний танхимд “Нээлттэй хаалга”-ны өдөрлөгөөр нийт 75 иргэнд 225 ширхэг нууцлал бүхий үнэт цаасаар үйлчилгээ үзүүлсэн.

Геодези зураг зүйн чиглэлээр:

Иргэд олон нийтэд газрын харилцааны чиглэлээр болон орон нутагт хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлуудын талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилгоор аж ахуйн нэгж, албан байгууллагуудад “Мэдээллийн цаг”-аар ажиллах удирдамжийг гарган ажиллаж эхлээд байна. Удирдамжинд 24 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулахаар тусгасан бөгөөд 2018 оны 3 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр хүртэл 14 аж ахуйн нэгж, байгууллагын/Ус-Ду ОНӨААТҮГ, ХХААГ, Боржигон чуулга, Номын сан, Музей, Сүмбэр сумын ЗДТГ, Аймгийн нэгдсэн эмнэлэг, Цахилгаан дамжуулах, Аймгийн цагдаагийн хэлтэс, Онцгой

байдлын газар, Төрийн банк, Хаан банк, УБТЗ-н ЭХУХ-н Чойр дахь хэсэг, Энхтүсдэм өрхийн эмнэлэг/ 221 иргэнд мэдээлэл хийж, зөвлөмж зөвлөгөө өгч ажиллаад байна.



Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран ажиллах 2018 оны гэрээг байгуулсны дагуу Сүмбэр, Шивээговь, Баянтал суманд тус тус “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгуулан ажиллалаа.

Тус өдөрлөгөөр иргэд олон нийтэд байгууллагын хийж буй томоохон ажлууд болон холбогдох хууль журмын нэмэлт өөрчлөлт, газар зохион байгуулалтын төлөвлөлт зэрэг холбогдох чиглэлүүдээр мэдээ, мэдээлэл бэлтгэн хүргэснээс гадна давхардсан тоогоор 197 иргэнд зөвлөгөө, үйлчилгээ үзүүлээ. Үүнд:

- 83 иргэнд гарын авлага, тараах материал тарааж, зөвлөгөө өгсөн
- 9 иргэний хүсэлтийн дагуу өмчлөлийн газарт хэмжилтийг хийж, эргэлтийн цэгийг нь газар дээр нь тэмдэглэн өгсөн
- 117 иргэнд газар өмчлөлийн материал хүлээлгэн өгч үл хөдлөх хөрөнгөө баталгаажуулахыг зөвлөн ажиллалаа.



Барилга, хот байгуулалт, оронсууц, нийтийнажахуй, барилгын материалын чиглэлээр:

Газрын харилцаа болон барилга, хот байгуулалтын чиглэлээр 6 албан байгууллагад мэдээллийн цаг хийж ажиллаж байна.

Хот байгуулалтын чиглэлээр:

- Сүмбэр сумын 1-р багт нийтийн бие засах газрын ажлын төсвийг, техникийн тодорхойлолтын хамт боловсруулав. /40,0 сая төгрөг/
- “ЗУУН НАЙМАН ОЙЛ” ХХК-ийн газрын тосны бүтээгдэхүүний агуулахын технологийн шинэчлэлт болон гал унтраах суурин системийн зурагтөсөлболовсруулахархитектуртөлөвлөлтийндаалгаварыг боловсруулав.

Мэдээ тайлан:

- БХБЯаманд аймгийн төвүүдийн бохир усны цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төслийн техникийн даалгавар боловсруулахад шаардагдах нэмэлт мэдээлэл болон Аймгийн хэмжээнд ашиглагдаж буй орон сууцны талбайн хэмжээг/м2/ ОНӨААТҮГазруудаас гаргуулан авч судалгааг хүргүүлсэн.
- БХТөвд орон сууцанд амьдардаг 10 өрх, гэр хороололд амьдардаг 22 өрхөөс орон сууцны эрэлтийн судалгааг авч, 2017 онд аймгийн хэмжээнд хийгдсэн төсөл арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажлын судалгаа зэргийг тус тус гарган хүргүүлэв.

Захиалагчийн хяналтын ажил:

- Нийтийн эзэмшлийн 8,15 дугаар байрны фасад засварын ажлыг “Гурван дэлгэр”ХХКомпани гүйцэтгэж байна. Ажлын явц 50%



- Сүмбэр сумын 100 хүүхдийн/канад/ цэцэрлэгийн барилга угсралтын ажил 2018.04.10-наас эхлэн дотор засал, сантехникийн ажлууд хийгдэж байна.



- Сүмбэр сум, 3-р баг “Зуух”-ны засварын ажлыг гүйцэтгэгч компани үргэлжлүүлэн дээвэр болон дотор заслын ажлыг гүйцэтгэж байна.



Аймгийн телевиз болон байгууллагын цахим хуудсанд байршуулсан зар

- Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд 2016 онд болон өмнөх жилүүдэд газар өмчлөх хүсэлтээ өгөөд материалаа аваагүй иргэд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас ирж газар өмчлөлийн материалаа авч, үл хөдлөх хөрөнгөө баталгаажуулах тухай зар
- Иргэн ААНБайгууллагууд газрын төлбөрөө барагдуулах тухай зар
- Баянтал суманд 2017 онд газар өмчлөх хүсэлт өгсөн иргэд Баянтал сумын газрын даамлаас материалаа авах тухай зар
- Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны зар
- Сүмбэр суманд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах тухай зар

Нэг цэгийн үйлчилгээгээр үзүүлсэн үйлчилгээ:

- Газар эзэмших эрх шилжүүлэх талаар эрх зүйн зөвлөгөө 15 иргэнд
- Газар өмчлөх эрх шилжүүлэх талаар эрх зүйн зөвлөгөө 27 иргэнд
- Газрын төлбөрийн талаар лавлагаа мэдээлэл 19 иргэнд тус тус өгсөн.
- Газар өмчилсөн иргэдийн бүртгэлээс лавлагаа мэдээлэл 56 иргэнд
- Газрынөвзалгамжлынталаарэрхзүйнзөвлөгөө3 иргэнд
- Газар өмчлөх өргөдлийн маягт 2 иргэнд
- Газар эзэмшилт, ашиглалт үүнтэй холбоотой баримт бичгийн талаар зөвлөгөө 3
- Сумдын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний талаар мэдээлэл 6 иргэнд
- Газрын харилцааны чиглэлээр гаргасан гарын авлага тараах материал 16 иргэнд тус, тус өгч үйлчилсэн байна.
- Говьсүмбэр аймгийн 1 дүгээр багт ЦДҮС-ТӨХК-ний баруун урд талд нарны цахилгаан станцын зориулалтаар эзэмшүүлэхтөсөлсонгоншалгаруулалтынмэдээ



ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР